

**“ЛИМИТЭД ЭКО ПРОТЕКТ” ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА**



**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД БАЙРЛАХ
“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН “ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ”- НИЙ
ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо 11-р хороолол
Их тойруу 82, Одкон холдинг 309а тоот
Утас: 99296506*

2025 ОН



АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн тодорхойлолт	4
1.2. Төслийн хүчин чадал	5
1.2.1 Тэсрэх материалын агуулахын хүчин чадал	5
1.2.2. Тэсрэх материалын агуулахын барилга	6
1.2.3. Төслийн талбайн дэд бүтэц	9
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
2.1 Уур амьсгал	12
2.2 физик газарзүй	12
2.3 Геоморфологи	13
2.4 Гадаргын ус	13
2.5 Хөрсөн бүрхэвч	14
2.6 Ургамлан бүрхэвч	15
2.7 Амьтны аймаг	16
2.8 Түүх соёлын дурсгалт зүйлс	16
2.9 Нийгэм эдийн засаг	16
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	22
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	22
3.2 ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ	22
3.3 ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	23
3.4 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ	24
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	25
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ	28
БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	34
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	35

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршил	5
Зураг 2. Тэсрэх материалын агуулахын зураг төсөл	6
Зураг 3. Тэсрэх материалы агуулахын өнөөгийн байдал	7
Зураг 4. Харуулын байр	9
Зураг 5. Аммиакийн шүүний хамгаалалт хашаа	11
Зураг 6. Төслийн талбайн Аянга зайлуулагч	12
Зураг 7. Төслийн байгалийн бүс бүслүүр	13
Зураг 8. Төслийн талбайн туул голын усны сав газарт хамаарна	14
Зураг 9. Төслийн талбайн хөрсний хэв шинж	15
Зураг 10. Төслийн ургамлан бүрхэвч	16



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Төслийн товч мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Төслийн талбайн координат	4
Хүснэгт 3. Аммиакийн шүү хадгалах хамгийн их багтаамж	7
Хүснэгт 4. MNS 4747:99 Монгол улсын стандартаар батлагдсан Аммиакийн шүү хэрэглээ Зориулалт .	8
Хүснэгт 5. Худгийн байршил: Гүний худаг	10
Хүснэгт 6. Төслийн талбайн зам талбайн усалгаа	10
Хүснэгт 7.Ногоон байгууламжийн усалгаа	10
Хүснэгт 8. Нийт ус хэрэглээний тооцоо	10
Хүснэгт 9.Налайх дүүргийн хүн ам	16
Хүснэгт 10.Налайх дүүргийн эрүүл мэнд.....	17
Хүснэгт 11.Нийт өвчлөл	17
Хүснэгт 12. Нийт үзлэг	18
Хүснэгт 13. Дүүргийн гамшиш эрсдэлийн судалгаа, жил бүрийн эхний XI сард.....	19
Хүснэгт 14.Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн эхний XI сард.....	20
Хүснэгт 15. Налайх дүүргийн аж үйлдвэр.....	20
Хүснэгт 16. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөх байдлын үнэлгээ.....	22
Хүснэгт 17. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	23
Хүснэгт 18. Гадаргын болон гүний усанд нөлөөлөх байдлын үнэлгээ	23
Хүснэгт 19. Ургамлан нөмрөгт үзүүлэх болзошгүй нөлөөлөл	24
Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн	25
Хүснэгт 21. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	26
Хүснэгт 22.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	30
Хүснэгт 23.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	30
Хүснэгт 24. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө	33
Хүснэгт 25. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө	33
Хүснэгт 26. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө	34
Хүснэгт 27. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	35



БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тодорхойлолт

"Цэцүүх Трейд" ХХК нь 1996 онд байгуулагдсан, химийн төрөл бүрийн бодис, урвалж, лаборатори болон хүн, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж бодис, шил сав, туслах хэрэгсэл худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг компани юм.

Үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн дотоодын аж ахуй нэгжүүдтэй энэ чиглэлээр идэвхи санаачлагатай ажилласаны үр дүнд гадаад, дотоодын хамтран ажиллагч байгууллагуудын тоо байнга нэмэгдсээр байгаа юм.

Өнөөдрийн байдлаар дотоодын 3000 гаруй аж ахуй нэгж, АНУ, ОХУ, Япон, ХНБГУ, БНСУ, БНХАУ, Итали зэрэг 12 улсын 30 гаруй нэр хүндтэй компаниудтай хамтран ажиллаж, хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

Цэцүүх трейд компанийн хамт олон нь үйл ажиллагаандаа Олон улсын чанарын удирдлагын менежментийн ISO9001:2015, байгаль орчны менежментийн ISO14001:2015, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн OHSAS18001:2007 стандартуудыг цогцоор нэвтрүүлсний (сертификатуудыг авсан) дээр Үндэсний татварын албаны "Найдвартай татвар төлөгч"-өөр 2 удаа, найдвартай татвар төлөгч "Хаяг эзэмшигч" байгууллага болон Улаанбаатар хотын Нийгмийн даатгалын газрын "Шилдэг ажил олгогч, шилдэг шимтгэл төлөгч"-өөр тус тус шалгарсан болно.

Тус компани 2018 оноос химийн төрөл бүрийн бодис, материалын цогц үйлчилгээ

- Импорт
- Борлуулалт
- Тээвэр ложистик, хүргэлт
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчлага
- Хэрэглэгчийн ашиглалт, хадгалалтын явц дахь хяналт, зааварчлага
- Сав, баглаа боодлыг буцаан татаж, боловсруулах-г


Хүснэгт 1.Төслийн товч мэдээлэл

Төслийн нэр:	“Тэсрэх материалын агуулах”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Цэцүүх трейд” ХХК
Төслийн байршил:	Улаанбаатар хот, Налайх дүүрэг 3-р хороо
Төслийн зорилго:	Налайх дүүргийн нутагт байршилтай өөрийн эзэмшлийн талбайд үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын гол түүхий эд болох аммиакийн шүүний байнгын түгээх агуулах байгуулан дотооддоо уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд аммиакийн шүү тогтмол нийлүүлэх зорилго тавин ажиллаж байна.
Регистрийн дугаар:	2066521
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Цэцүүх оффис, үйлдчилгээний төв. Утас: 70179777, 70187798, 70179677
Утас:	99119202

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р багийн нутагт харьяалагдах ба Налайх дүүргийн төвөөс зүүн урагшаа 13.5 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 45 км, Налайх дүүргийн нисэх онгоцны буудлын талбайгаас урагш 4.9 км зайд тус тус байрлана.

Хүснэгт 2. Төслийн талбайн координат

№	X	Y
1	675950.67	5288310.48
2	676050.67	5288310.48
3	676050.67	5288210.48
4	675950.67	5288210.48
10000 м.кв		



Зураг 1. Төслийн байршил

1.2. Төслийн хүчин чадал

1.2.1 Тэсрэх материалын агуулахын хүчин чадал

Аммиакийн шүү нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэрлэлд түгээмэл хэрэглэгддэг химийн бодис бөгөөд шинж чанарын хувьд 5.1 буюу исэлдүүлэгч шинж чанартай бодисын ангилалд хамаарна. Уг агуулахыг ТАААНД-ын 7-р бүлгээс аммиакийн шүүг хадгалахтай холбоотой заалтууд болон Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS6458:2014 стандартын холбогдох заалтуудад нийцүүлэн байгуулна.

Агуулах нь дотроо 50 тн багтаамжтай 10 тасалгаатай байх бөгөөд тасалгаа бүрийн тусгаарлагч дотоод хананы материал нь “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал. БНБД 21-01-02”-ын 1-р хүснэгтэд заасан REI150, бусад төрлийн бодисын агуулахын таславч хана нь REI45-ын шаардлагыг хангасан болно.

Тэсэлгээний материал хадгалах агуулах нь дараах зохион байгуулалттай талбайгаас бүрдэнэ.

- Тус бүр 500 тн багтаамжтай 1 ширхэг аммиакийн шүүний агуулах;
- Ачаа буулгах, аммиакийн шүү ачиж буулгах зориулалтын талбай;

- Гэрэлтүүлэг, камерын шон;
- Гал эсэргүүцэх хэрэгсэл бүхий галын сарай
- Шалган нэвтрүүлэх байр /хаалганы гадна/
- Аянгаас хамгаалах байгууламж;
- Авто зогсоол /аммиакийн шүү ачсан болон бусад авто техникүүд/;
- Хамгаалалтын хашаа гэх мэт.

Уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын үндсэн түүхий эд болох аммиакийн шүүний агуулахын хамгийн их багтаамж нь нэг талдаа тус бүр 50 тн хадгалах багтаамж бүхий 10 тасалгаатай нэг агуулах 500 тн багтаамжтай байна.



Зураг 2. Тэсрэх материалын агуулахын зураг төсөл

1.2.2. Тэсрэх материалын агуулахын барилга

Агуулахын дотор талд 1.15*1.0*1.1 метр /урт*өргөн*өндөр/ хэмжээтэй 1000 кг-аар савлагдсан аммиакийн шүүг доод эгнээндээ 30 ширхэг, дээр давхарлаж хураахдаа түүний зааг хэсгээр амыг дарах байдлаар дээд эгнээндээ 20 ширхэг нийтдээ нэг тасалгаанд 50 ширхэг шүү өрж хураана. Агуулахын дотор өрөлтийг сэрээт өргөгчөөр гүйцэтгэнэ. Уг хэсэгт барилгажих талбайн хэмжээ нийт 585 м² байх бол ачилт буулгалтын зам талбайн хэмжээ 1095 м², технологийн зам талбайд 475 м² зэрэг талбайн ашиглахаар байна.

Агуулахын хашааны гадна талд хашаанаас хамгийн ойрдоо 10 м зайд үерийн ус зайлуулах шуудуу татагдах бөгөөд шуудууны нийт урт нь 470 м болох бөгөөд тэнд хийгдэх уулын ажлын хэмжээ нь 352.5 м³ болж байна. Агуулахын гадна талд хаалганаас авто зогсоол байх бөгөөд авто зогсоолын хэсэг болон агуулахын бүсэд нэвтрэх тээврийн замын талбай нь 700 м² болж байна.



Зураг 3. Тэсрэх материалы агуулахын өнөөгийн байдал

Агуулахад хадгалах бодис

Хүснэгт 3. Аммиакийн шүү хадгалах хамгийн их багтаамж

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томьёо	CAS дугаар	Шаардлагатай хэмжээ, тн
1	Аммиакийн шүү	Ammonium nitrate	NH ₄ NO ₃	6484-52-2	50000
2	Сульфосилицилийн хүчил	Sulfosilicic acid	C ₇ H ₆ O ₆ S*2H ₂ O	5965-83-3	100
3	Азотын хий /галын хор цэнэглэдэг/	Nitrogen gas	N ₂	7727-37-9	1000
4	Азотын хүчил	Nitric acid	HNO ₃	7697-37-2	500
5	Аммиакийн шүү /мөхлөгт /	Ammonium nitrate granular	NH ₄ NO ₃	6484-52-2	50000
6	Аммиакийн шүү /сүвэрхэг/	Ammonium nitrate porous prilled	NH ₄ NO ₃	6484-52-2	20000
7	Аммонийн гидроксид	Ammonia	NH ₄ OH	1336-21-6	30000
8	Мочевин	Urea	CO(NH ₂) ₂	57-13-6	1500
9	Натрийн карбонат	Sodium carbonate	Na ₂ CO ₃	497-19-8	500
10	Натрийн шүү / Натрийн	Sodium nitrate	NaNO ₃	7631-99-4	6000



	нитрат				
11	Натрийн нитрит	Sodium nitrite	NaNO ₂	7632-00-0	30000
12	Полимер бөмбөлөг	Polymer microsphere			60
13	Тиомочевин	Thiourea	C ₇ H ₅ N ₃ O ₅	62-56-6	50
14	Натрийн тиоцианат	Salts of thiocyanic acid	NaSCN	540-72-7	35000
15	Эмульгатор	Emulsifier	***	8012-56-4	10000
16	Этилен гликол	Ethylene glycol	C ₂ H ₆ O ₂	***	2000
17	Аммонийн нитрат барьцалдуулагч бодис	AN conditioner Gelling Agent	Холимог	***	5000
18	АНФО	ANFO	Холимог	***	1000
19	Хөөсрүүлэгч	Flotanol 7196, 16933, 18581, 18584, Flottec F145, F150, F173	Холимог	***	5000
20	Цуглуулагч	Flottec collector 1234, 2075, 2644, 2801	Холимог	***	5000
21	Сульфакарбамид	Sulfacarbamide	C ₇ H ₉ N ₃ O ₃ S	547-44-4	500
22	Цуглуулагч ксантат	SIPX /Xantate/	C ₇ H ₅ N ₃ O ₆	118-96-7	10000
23	Полиизобутилен саксиник ангидрид /Пивса/	PIBSA NB4745, NB2424	Холимог	***	4000
24	Эмульсын тэсрэх бодис ≥32 мм, >70 мм	Emulsion Explosive >32 mm, >70 mm	Холимог	***	5000
25	Аммонитын тэсрэх бодис ≥50 мм	Ammonite Explosive >50 mm	Холимог	***	1000

Агуулахын дотор талд 1.15*1.0*1.1 метр /урт*өргөн*өндөр/ хэмжээтэй 1000 кг-аар савлагдсан аммиакийн шүүг доод эгнээндээ 30 ширхэг, дээр давхарлаж хураахдаа түүний зааг хэсгээр амыг дарах байдлаар дээд эгнээндээ 20 ширхэг нийтдээ нэг тасалгаанд 50 ширхэг шүү өрж хураана. Агуулахын дотор өрөлтийг сэрээт өргөгчөөр гүйцэтгэнэ.

Аммиакийн шүүний шинж чанар: Аммиакийн шүү нь марк төрлөөсөө хамааран зориулалт нь өөр өөр байдаг.

Хүснэгт 4. MNS 4747:99 Монгол улсын стандартаар батлагдсан Аммиакийн шүү хэрэглээ Зориулалт

№	Шүүний нэр, марк	Хэрэглээ
1	Ердийн мөхлөгт Марк-А Аммиакийн шүү Марк-Б	Эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэхэд ашиглах
2	Нүх сүвэрхэг мөхлөгт Аммиакийн шүү Марк-П	Бордооны зориулалтаар болон уурхайн үйлдвэрийн нөхцөлд энгийн тэсрэх бодис бэлтгэх
3	Сэвсгэржүүлсэн Аммиакийн шүү	Уурхай үйлдвэрийн нөхцөлд энгийн тэсрэх бодис бэлтгэх

Эмульсийн тэсрэх бодисын усан уусмалын найрлагад /А-маркийн ердийн мөхлөгт аммиакийн шүү/-ыг, харин эмульсийн тэсрэх бодисын сүүлийн нэмэгдэл болон энгийн найрлагатай тэсрэх бодист нүх сүвэрхэг Аммиакийн шүүг үндсэн түүхий эд болгон ашиглана. Талстлаг болон мөхлөгт, хайлах температур нь 169°C. Чийг шингээх, барьцалдах

бөөгнөрөх шинжтэй. Усанд хялбар уусах ба уусахдаа дулаан шингээдэг. Усны температур өндөр бол уусалт нь илүү явагдана. Эмульсийн тэсрэх бодист аммиакийн шүү нь исэлдүүлэгчийн үүрэгтэй. Аммиакийн шүүний 81%-ийн концентрацитай исэлдүүлэгчийн халуун усан фаз бэлтгэхэд “НФ” диспергатор агуулаагүй аммиакийн шүүг үндсэн түүхий эд болгон ашиглана. Аммиакийн шүү нь их хэмжээний дулаан шингээн усанд хялбархан уусдаг бөгөөд уусалтын дулаан нь 330 кДж/кг байна. Аммиакийн шүүний уусалт 20°C-д 1900 гр/л, 80°C хэмд 6000 гр/л байна.

Аммиакийн шүү-(NH_4NO_3) буюу азотын хүчлийн давс нь O_2 -60%, N-35%, H-5%-ийн нэгдэл юм. Цагаан өнгөтэй талст хэлбэртэй хайлах температур нь 169.6°C -д хайлдаг. Детонацийн хурд -2570 м/с.

1.2.3. Төслийн талбайн дэд бүтэц

1.2.3.1 Цахилгаан хангамж

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байгуулагдах аммиакийн шүүний агуулахын цахилгааны хэрэглээг Налайх дүүргийн 110/35/10 кВ-ын Налайх дэд станцаас 6кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татан ашиглахаар төлөвлөн УБЦТ Станцаас техникийн нөхцөл авахаар хүсэлтээ хүргүүлэн ажиллаж байна. Агуулахын цахилгааны гол хэрэглэгчид нь хашаа ачилт буулгалтын зам талбайн гэрэлтүүлэг, агуулахын дотоод гэрэлтүүлэг, шалган нэвтрүүлэх харуулын байрны дулаан хангамж, агуулахын бүсэд байршуулах хяналтын камер болон ахуйн хэрэглээ байна. Агуулахын цахилгааны эх үүсвэр тасалдсан тохиолдолд гэрэлтүүлэг, камер, бусад хэрэглээг хангах нөөцийн дизель генератор байх зайлшгүй шаардлагатай бөгөөд нөөцийн дизель генератор нь газардуулгатай, гадуураа агаарын бүрэн сэлгэлт бүхий байртай байна.

1.2.3.2 Дулаан хангамж

Харуулын шалган нэвтрүүлэх байрыг хүйтний улиралд цахилгаан халаагуур ашиглан халаахаар төлөвлөж байна. Уг барилгын талбайн хэмжээнээс хамааруулан бүрэн халаах хүчин чадалтай цахилгаан халаагуур сонгож авч ашиглана.

1.2.3.3 Харуулын байр

Харуул хамгаалалтын ажиллагсдын үндсэн үүрэг нь агуулахын захиргаанаас зөвшөөрөл олгогдсон зочид, ажиллагсдаас бусад хүнийг агуулахын талбайд оруулахгүй байх, агуулахыг аливаа гаднын халдлага, хулгайгаас хамгаалах бөгөөд захиргааны зөвшөөрлөөр агуулахад нэвтэрч буй ажиллагсад, зочдын бүртгэлийг тогтмол хийх, агуулахын орчинд долгион цацруулах төхөөрөмж, гар утас, гал гаргах хэрэгсэл зэргийг оруулахгүй байх үүрэг хүлээнэ. Мөн агуулахын бүсэд мал амьтан орохоос сэргийлнэ.



Зураг 4. Харуулын байр

1.2.3.4 Усан хангамж

Ахуйн хэрэглээний ус-гүний худаг



Ахуйн хэрэглээний усыг 1 гүний худгаас хангана. Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 12 дугаар хавсралт “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”-д хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байранд 1 хүнд хоногийн дундаж усны хэрэглээ нь 80 л болно. Тэсрэх материалын агуулахад нийт 7 хүн 264 хоног ажиллана.

Хүснэгт 5. Худгийн байршил: Гүний худга

Усны хэрэглээний төрөл	Төслийн хугацаа, хон/жил	Норм	Хүний тоо	Ус хэрэглээ	
				м³/хон	м³/жил
Унд-ахуйн	264	80л/хон/хүн	7	0.56	147.8

Зам, талбайн усалгаа

Тоосжилт багасгах, зам талбайг услах усыг Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралт “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-ын дагуу 1 м² гудамж, зам, талбай усалгааны норм 2л болно.

Хүснэгт 6. Төслийн талбайн зам талбайн усалгаа

Усны хэрэглээний төрөл	Усалгаа жил/хоног	Норм л/м²	Талбайн хэмжээ м²	Ус хэрэглээ	
				м³/хон	м³/жил
Тэсрэх материалын агуулах	80	2.0л	210	0.42	33.6

Ногоон байгууламжийн усалгаа

Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралт “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-ын дагуу 1 м² цэцэрлэг, зүлэг ногоо услах усалгааны норм 4 л болно.

Хүснэгт 7. Ногоон байгууламжийн усалгаа

Усны хэрэглээний төрөл	Усалгаа жил/хоног	Норм	Модны хэмжээ	Ус хэрэглээ	
				м³/хон	м³/жил
Цэцэрлэг зүлэг, ногоо услах	80	4 л	350 ш	1.4	112


Хүснэгт 8. Нийт ус хэрэглээний тооцоо

Усны зарцуулалт	Норм, л	Хэмжээ	Усны хэрэглээ, м³/хоног	Жилийн хэрэглээ, м³/жил
Унд ахуйн хэрэглээ	80	7 хүн	0.56	147.8
Зам, талбайн усалгаа	2	м²	0.42	33.6
Ногоон байгууламжийн усалгаа	4	м²	1.4	112
Нийт			2.38	293.4

1.2.3.5 Хамгаалалтын хашаа

Аммиакийн шүүний агуулах нь онцгой объектод тооцогдох тул түүнд гаднаас мал амьтан болон гаднын хүн нэвтрүүлэхгүй байх зорилгоор агуулахын талбайг тойруулан хамгаалалтын хашаа байгуулах шаардлагатай ба 24 цагийн байнгын харуул хамгаалалттай байлгана. “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” стандартын дагуу агуулахыг тойруулан 1.8 метрээс багагүй өндөртэй байхаар заасан байдаг бөгөөд ТАААНД-ийн 738-р зүйлд агуулах нь өргөст

тор, тоосго, чулуу, төмрөөр хийгдсэн 2 метрээс багагүй өндөртэй байна гэсэн заалтын дагуу уг аммиакийн шүүний агуулахад 2 метр өндөртэй төмөр хашаа барихаар төлөвлөж өгсөн. Энэ нь дээрх дүрэм, стандартын аль аль заалтыг бүрэн хангахаар байна гэж үзсэн. Хашаа нь цоожтой, шөнийн цагаар гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй байна. Хашаа нь шалган нэвтрүүлэх байрны хэсэгт авто машин болон явган хүн орж, гарах зориулалттай гүйдэг хаалгатай байх ба хаалга нь цоожтой байхаар тооцож байгуулна.



Зураг 5. Аммиакийн шүүний хамгаалалт хашаа

1.2.3.6 Хяналтын камер, гэрэлтүүлэг


Аммиакийн шүүний түгээх агуулахын хашааны үүд болон агуулахуудыг эргэн тойрон бүхэлдээ гэрэлтэх боломжтой байрлалуудад шөнө гэрэлтэлт сайтай гэрэлтүүлгийг байрлуулна. Гэрэлтүүлгийн шон нь 6 м-ээс багагүй өндөртэй байна. Камержуулалтыг гэрэлтүүлгийн шонгийн доор буюу газрын түвшнөөс 4 м хүртэл өндөрт байрлуулах бөгөөд камерын харах чиглэл нь гэрэлтүүлгийн тусгалын чиглэлтэй нэг хэмд байх шаардлагатай юм. Энэ нь гэрлийн ойлтоос шалтгаалан камерын харах орчин хязгаарлагдахаас сэргийлэх давуу талтай. Камерын хүчин чадал нь 90 градуст 100 м хүртэл тусгалтай байх бөгөөд харуулын байранд байрлах дэлгэцээр хянах боломжтой байна. Хяналтын камер нь шөнийн бичлэгтэй байхаас гадна хөдөлгөөн мэдэрдэг, зураг болон бичлэгийн нягтрал өндөртэй байх шаардлагатай бөгөөд бичигч нь камерын бичлэгийг хамгийн багадаа 1 сар хадгалах багтаамж бүхий санах ойтой хард дисктэй байна.

1.2.3.7 Харуул хамгаалалт

Агуулахыг нийтэд нь хянах боломжтой шалган нэвтрүүлэх байр нь хашааны зүүн урд байрлах бөгөөд хамгаалалтын тусгай хэрэгсэл болон холбоогоор бүрэн хангагдсан гэрээт харуул хамгаалалтын албыг 24 цагаар ажиллуулдаг.

1.2.3.8 Аянга зайлуулагч

Аммиакийн шүүний аянга хүлээн авагч, гүйдэл зайлуулагч, газардуулах байгууламжийн бүрдлээр хамгаална. Аянга зайлуулагч нь өөр өөрийн газардуулгатай байна. Агуулах нь аянгын шууд цохилт болон аянгын хоёрдогч үйлчлэлээс хамгаалагдсан байгууламжтай баригдана. Аянга зайлуулагч дээр аянга буух үед их хэмжээний хэт хүчдэл үүсэж хажуугийн объектод урвуу ниргэлэг үүсгэхгүйн тулд аянга зайлуулагч ба объект хоорондын зөвшөөрөгдөх хамгийн бага зай нь агаараар 5 м-ээс багагүй байх шаардлагатай. Аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулгыг механик гэмтлээс хамгаалах, эсэргүүцлийн хэмжээг тогтвортой байлгахын тулд агуулахын гадна талд газрын гадаргаас доош 0.8 м-ийн гүнд, түүний сууриас 0.5-1 м зайтай газарт суулгана.



Зураг 6. Төслийн талбайн Аянга зайлуулагч


БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Уур амьсгал

Уг төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Горхи - Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрийн гадаргуугийн өвөрмөц нөхцөл бүс нутгийн уур амьсгал бүрэлдэн тогтох нэгэн хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл Хан Хэнтийн нурууны их уулс нь Монгол орны төдийгүй Төв Азийн уур амьсгал бүрэлдэхэд Сибирээс их говь руу өөрөөр хэлбэл уртгагийн дагуу түрж тогтсон байна. Хан Хэнтийн нурууны байгалийн чиглэлийн судалгаа, уур амьсгалын ерөнхий тодорхойлолт хийгдсэн. Гэвч нарийвчилсан судалгаа хомс байна. Харин Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар байгуулагдсанаас хойшхи хугацаанд судалгаа өргөжиж байгаль орчин зүйн ажиглалтыг нилээд өргөн хүрээтэй, байгаль хамгаалагчдын нэгэн ажил болгож байгаа нь судалгааны суурь болж байна.

2.2 физик газарзүй

Монгол орны ой хээрийн бүсэд оршиж, уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй, хуурайдуу зунтай, хахир хатуу өвөлтэй нутагт багтана. Өвөлдөө -20°C - 30°C хэм хүрч хүйтрэн, зундаа $+23^{\circ}\text{C}$ + 30°C хүртэл халдаг. Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нутаг бүхэлдээ Налайх дүүрэгт хамаарагдаж, Хэнтийн нуруунаас эх авсан Туул гол дүүргийн нутгаар урсдаг ба түүний цутгал, гол горхиуд нь Хойт мөсөн далайн савд багтдаг.




Зураг 7. Төслийн байгалийн бүс бүслүүр

2.3 Геоморфологи

Хэнтий нуруу нь геологийн тогтцын хувьд нилээд цомхон боловч өвөрмөц дүр төрхтэй. Хэнтий нуруунд анх төрмөл, эрт төрмөл, дунд төрмөлийн эриний настай гүний болон тунамал чулуулаг тархсан байна. Эрт төрмөлийн чулуун нүүрсний галавын нүүрст ба нүүрстөрөгчит шаварлаг занар, Туул, Заан голуудын эхэн сав газраар, девоны ангилагдаагүй чулуулаг, цахиурлаг занар, хас, нүүрст ба нүүрстөрөгчит шаварлаг занар зэрэг чулуулаг Өвөр Минж, Туулын эх, Тэрэлжийн сав газраар тархсан байна. Хөрс үүсгэгч дөрөвдөгчийн аллюви, эллюви, делюви, пролюви, мөсдлийн хурдсууд Хэнтийд өргөн тархсан байдаг. Неоген, дөрөвдөгчийн хурдсууд уулс хоорондын хотгор, хонхор, голуудын хөндийг дүүргэсэн байдгаас гадна төвийн өндөр уулсын хавьд зарим хэсэгтээ аллювийн хурдас, дөрөвдөгчийн өмнөх үеийн хурдас алаг цоог тархана.

2.4 Гадаргын ус

Усзүйн хувьд Хойд мөсөн далайн ай савын Туул голын ай савд багтах бөгөөд олон жилийн дундаж урсац нь 100м-ээс илүү бүс нутагт хамаарна. Уулын эргэн тойрны 20 орчим амнаас гол горхи эх авч зарим нь Туул голд, үлдсэн хэсэг нь уулын хаяа, хормой хотгор гүдгэрт хүрч сэвсгэр хурдсанд шурган орно. Уулаас эх авсан голоос 36.2 км урт Түргэний гол, 33.3 км урт Баруун, Зүүн Зуун Модын гол, 32.6 км Хүрхрээ голуудыг нэрлэж болно. Мөн хэд хэдэн эмчилгээний ач холбогдолтой рашаан булаг байдаг.




Зураг 8. Төслийн талбайн туул голын усны сав газарт хамаарна.

2.5 Хөрсөн бүрхэвч

Налайх хот нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хэнтийн иж мужийн Хэнтийн баруун дэд мужид ойт хээрийн бүсэд оршдог.

Тэсрэх материалын агуулахын хөрсний хэмжилт дээжлэлт хийхэд Хар хүрэн өнгөтэй, нягт хатуу, хуурай, ургамлын үндэс ага зэрэг тархсан, бөөмөн бүтэцтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, чулуу тархаагүй, шилжилт өнгөөр тод албай нь хар хүрэн хөрсний хэв шинжид хамаарч байна.




Зураг 9. Төслийн талбайн хөрсний хэв шинж

2.6 Ургамлан бүрхэвч

БЦГ-ын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ойн мужийн Өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрог, Евразийн хээрийн мужийн, Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрогт тус тус хамаарагдана (Юнатов, 1950).

Тэсрэх материалын агуулахын талбайн ургамлын судалгаагаар Хялгана-хиаг бэлчээрийн хэв шинжтэй бөгөөд зэрэг Дэрвээн хазаар өвс /*Cleistogenes squarrosa*/, Ширэг уулалж /*Carex duriuscula*/, Агь /*Artemisia frigida*/ зэрэг ургамал 10-25%-ийн бүрхэцтэй *Cop1* арвитай, Имт гичгэнэ /*Potentilla bifurica*/, Арзгар согсоолж /*Heteropappus hispidus*/, Ишгүй гичгэнэ /*Potentilla acaulis*/, Буурал гандбадраа /*Veronica incana*/, Эмийн багваахай /*Taraxacum officinalis*/, Шар цаграс /*Medicago falcata*/, Замын тавансалаа /*Plantago depressa*/, Хялгасан дэвхэргэн цагаан /*Arenaria capillaris*/ зэрэг ургамал 5-10%-ийн бүрхэцтэй *Sp* арвитай тохиолдоно. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 1м² талбайд 85%, 10 м² талбайд 80%, ургамлын дундаж өндөр 2-20 см, зүйлийн тоо 11 байна.



Зураг 10. Төслийн ургамлан бүрхэвч

2.7 Амьтны аймаг

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрт 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болон нүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 16 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг.

2.8 Түүх соёлын дурсгалт зүйлс

Төслийн талбайд түүх соёлын дурсгалт зүйл байхгүй.

2.9 Нийгэм эдийн засаг

Налайх нь Улаанбаатар хотын 9 дүүргийн нэг бөгөөд төвөөс алслагдсан. Ардын хувьсгалаас өмнө энд Хятадын пүүсүүд нүүрс олборлодог байсан. Засаг захиргааны хувьд 8 хороотой. Хүн амын тоо 39000. Налайх нь төмөр зам, нисэх онгоцны буудал, эрчим хүч, шилэн кабель гэх мэтчилэн дэд бүтэц сайтай. Налайх дүүрэг нь Нийслэлээс зүүн урагш 36 км-т өвөлдөө -24с-27 хэм, зундаа +23с+26 хэмийн дундаж температуртай ойт хээрийн бүсэд оршдог. Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумтай хиллэдэг.


Хүснэгт 9.Налайх дүүргийн хүн ам

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022
Суурин хүн ам, жилийн эцэс	Тоо	36911	37715	38690	38929	-
Ажилгүйчүүд сарын эцэст	Тоо	191	249	248	104	197

Үүнээс эмэгтэй	Тоо	111	145	135	71	92
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	761	789	789	849	792
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	Тоо	479	382	352	11909	4752
Бүртгэсэн гэмт хэрэг	Тоо	421	300	249	255	313
Орон нутгийн төсвийн орлого	Сая төгрөг	17 594.5	20 165.0	31941.8	22 882.9	14 219.2
Орон нутгийн төсвийн зарлага	Сая төгрөг	16 231.3	19 951.9	32 392.1	21 696.4	14 409.5

2.9.1 Ажил эрхлэлт

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажилгүй иргэдийн тоо 197, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 93 хүнээр /89,4%/ өссөн ба 46,7 хувь нь эмэгтэйчүүд эзлэж байна.



2.9.2 Эрүүл мэнд

2022 оны эхний 11 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 54 (6.5%) нас баралт 51 (17.9%) тус тус буурсан байна

Хүснэгт 10.Налайх дүүргийн эрүүл мэнд

Үзүүлэлт	2020	2021	2022
Амаржсан эхийн тоо, бүгд	797	836	782
Амьд төрсөн хүүхэд	806	849	792
Амьгүй төрсөн	2	4	7
Эхийн эндэгдэл	1	2	-
Нас баралт	230	284	233
Үүнээс нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	9	14	8
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	12	45	24
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	172	195	155
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт	46	44	54

2022 оны эхний 11 сард бүртгэгдсэн нийт нас баралтын 66.5 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 23.2 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад нас барсан. 10.3 хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 11.Нийт өвчлөл

Үзүүлэлт	2020	2021	2022
Нийт халдварт өвчин	352	11 909	4752
Халдварт өвчин	56	11 678	4503
Хепатит В вирус	2	-	-
Хепатит С вирус	1	3	-



Менингет	1	-	-
Салхин цэцэг	15	6	10
Паротит	1	1	-
Бруцеллез	-	-	-
Елом	1	1	-
Дизентери	10	-	3
Гар, хөл, амны өвчин	9	5	4
Энтеровирус /х тодорхойгүй/	2	-	1
Сальмонеллез	-	-	-
Улаан эсэргэнэ	6	-	1
Хачигт риккетиз	2	-	-
Хачигт энцефалит	-	-	-
Ковид	6	11 662	4484
Сүрьеэ	40	48	28
Арьс өнгөний өвчин	256	183	221
Тэмбүү	75	70	92
Заг хүйтэн	62	51	67
Бэлгийн замын мөөгөнцөр	66	37	22
Трихомониаз	53	25	39
ХДХВ	-	-	1

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд хурц халдварт өвчнөөс 4752 хүн өвчилсөний 4484 нь корона вирус, 19 бусад төрлийн хурц халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7175 (20.7 дахин) хүнээр буурсан, сүрьеэгээр 28 хүн өвчилсөн нь 20 (41.6%) хүнээр буурсан байна. Арьс өнгөний өвчлөл 221 гарсан нь 38 (20.7%) буурсан байна.

Хүснэгт 12. Нийт үзлэг

	2019	2020	2021	2022
Урьдчилан сэргийлэх тарилга	7 231	7 450	7 135	7 091
Амбулаторын үзлэг	196 609	197 829	205 718	215 703
Ор хоног	46 972	43 833	55 351	49 115
Эмчийн тоо	78	87	84	84
Сувилагчийн тоо	105	108	100	100
Орны тоо	227	227	235	325

Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 6985 (4.8%) өсч, Урьдчилан сэргийлэх тарилга 44 (4.8%), ор хоног 6236 (11.2%), тус тус буурсан байна.

2.9.3 Дүүргийн төсөв

2022 оны эхний 11 сард дүүргийн төсөвт 9823.0 сая төгрөгийн татварын ордого төвлөрсөн байна.



Дүүргийн Онцгой байдлын хэлтэст 2022 оны эхний 11 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж нийт 275 аж ахуйн нэгж, байгууллагын обьектод 567 зөрчил илрүүлэн, 456 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 165, зөрчлийн тэмдэглэл 12, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 190, танилцуулга 10, гал түймэр унтраасан нотломж 57, гал түймэр гаргасан тухай акт 19, мэдэгдэл 230 дүгнэлт 6, галын зөвшөөрөл 11, хүргүүлсэн байна. Мөн обьектын гал түймрийн 57 дуудлагаар ажиллаж, 2975.6 сая төгрөгийн өм хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 13. Дүүргийн гамшиг эрсдэлийн судалгаа, жил бүрийн эхний XI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019	2020	2021	2022
Бүгд		50	47	46	57
Өмчийн хэлбэрээр:					
Төрийн өмч	Тоо	3	-	-	12
Хувийн өмч	Тоо	44	45	45	31
Аж ахуйн нэгж	Тоо	3	2	1	14
Гал түймэрт өртөж шатсан:					
Нас барсан	Хүүхэд	-	-	-	-
	Том хүн	-	1	-	-
Түлэгдэж бэртсэн	Хүүхэд	-	-	-	-
	Том хүн	-	-	-	-
Өвөл зуны сууц	Тоо	15	18	11	16
Гэр	Тоо	4	8	6	16
Нийтийн орон сууц	Тоо	-	2	-	-
Хог, хогийн суваг	Тоо	10	6	6	8
Машин техник	Тоо	3	6	4	5
Барилга байгууламж	Тоо	2	2	8	7
Малын хашаа саравч	Тоо	4	-	6	5



Шалтгаан:					
Цахилгааны	Тоо	3	9	14	30
Ил задгай асгасан үнс нурмаас	Тоо	5	4	12	7
Лаа, тамхи, шүдэнз	Тоо	3	-	6	5
Хүүхдийн болгоомжгүй үйл ажиллагаанаас	Тоо	-	-	2	-
Гагнуур, паялник бамбараас	Тоо	-	6	2	10
Пийшин зуухны цонолт	Тоо	2	4	1	5
Машин техник гэмтэл, буруу ашигласан	Тоо	-	1	5	-
Машин техникийн яндангийн оч болон цахилгааны очноос	Тоо	-	2	2	-
Архидан согтуурснаас	Тоо	-	2	-	-
Бусад	Тоо	4	4	1	-
Шалтгаан тогтоогдоогүй	Тоо	33	12	3	-
Аварсан эд хөрөнгө:					
Хүн	Тоо	-	26	4	-
Өвөл зуны сууц	Тоо	10	13	8	5
Гэр	Тоо	2	3	1	-
Барилга байгууламж	Тоо	2	6	1	17
Машин техник	Тоо	1	3	1	8
Нийтийн орон сууц	Тоо	-	1	-	-
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	Тоо	-	1	-	-
Малын хашаа саравч	Тоо	-	-	-	5
Эд хөрөнгө	Сая төгрөг	359.6	744.0	3 050.0	2.975.6

2022 оны эхний 11 сард дүүргийн Засаг даргын 32 удаагийн захирамжаар нийт 1551 иргэн, 139 аж ахуйн нэгжийн байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 14. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн эхний XI сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	94	8	394	1017	161	47	-	38

2.9.4 Аж үйлдвэр

2023 оны эхний 11 сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 11.2 хувиар өсч, дулаан хангамж 15.6 хувиар, усан хангамж 14.7 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 15. Налайх дүүргийн аж үйлдвэр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая/төг		
		2020	2021	2022	2020	2021	2022
Эрчим хүчний							



үйлдвэр:	Сая.квт.цаг	81.4	157.7	175.4	15.518.4	29 607.4	32.479.6
Цахилгаан	Мянган гкал	77.3	80.6	68.0	3 225.7	3.382.9	3.159.7
Дулаан	Мянган м³	753.2	1 013.0	863.6	653.3	1.365.8	862.4
Усан хангамж							
Олборлох үйлдвэр:							
Шохой	Тонн	39.272	39.7	29.9	392.7	410.6	376.6
Хайрга	Мянган м³	8.53	6.6	6.4	116.1	45.2	66.5
Элс	Мянган м³	21.3	64.3	43.6	186.0	497.4	493.6
Боловсруулах үйлдвэр:							
Тоосго	Мян.ширхэг	4808	5 389			1379.6	1367.6
Цемент	Мянган тонн	1896	34.5	5470	1385.1	4543.4	5666.1
Бетон зуурмаг	Мянган м³	-	12.7	29.2	2413.8	1904.4	2093.5
Аюултай хог хаягдал		-	1476.5	9.0	-	1852.9	1285.3
булах	Тонн	-	43.4			448.0	702.8
Аюулгүй хог		-	15.3	934.9	-	479.2	669.9
хаягдал зайлуулах	Мянган тонн	-	-	63.0	-	-	-
Оёдол /сурагчийн		32.1	2.2			22.4	95.0
дүрэмт хувцас/	Мян.ширхэг		1.2	15.9	621.5	51.1	39.7
Гэр ахуйн оёмол		31.6	134.5	-	31.6	35.5	-
эдлэл	Мян.ширхэг		159.2	-	18.6	42.9	-
Арьсан цүнх,		1.3	92.2			23.6	-
түрийвч эдлэл	Мян.ширхэг		5196.2	-	-	252.3	100.2
Берзинтэн цүнх		-	5.8	2.3	-	284.1	384.1
Бусад төрлийн	Мян.ширхэг	-		0.8	35.9		
оёмол эдлэл		135.5	22.3	-	31.3		23.4
Замаска	Тонн		19.5			30.2	37.5
Барилгын		105.0	1.3	-	28.7	37.1	25.4
шаардлагын хар	Тонн			-1484.5	177.8	15.5	-
замаска		84.8	2 573.0	7.7	238.1	21121.3	2936.9
Плитаны цавуу	Тонн	3 909.8	241.8			1.874.3	2724.3
Эрдэст нунтаг	Тонн	8.3				9210.5	228.6
Хэвлэлийн хор	Мянган ширхэг		1362.5	13.0		11546.5	13.4
Хүнсний			1689.7	12.6	59.6	9196.2	-
бүтээгдэхүүний			1453.5	2.3	42.0	1493.5	-
үйлдвэрлэл:		32.93	62.8		2.4	45.8	4756.8
Талх	Тонн	21.92	7.6	-		6042.1	
Нарийн боов,	Тонн		13.1	318.3			
жигнэмэг		0.2		357.0	15633.2		
Бялуу	Тонн			36.4	-		
Утсан, чанасан				2.2			
болон хагас		2507.6		-	-		
боловсруулсан мах	Тонн	-		-	-		
Үхрийн мах	Тонн			13.9	-		
Хонины мах		-			-		
Ямааны мах	Тонн	-			-		
Адууны мах	Тонн	-			1445.5		
Өлөн гэдэс	Тонн	-					
Элэгний нухаш	Мян.гогцоо	-					
Цэвэр ус	Тонн	4.2					
	Мянган литр						

2022 оны эхний 11 сард 47060 зөрчил шийдвэрлэсэн байна. 46133 иргэнийг 1600.0 сая төгрөгөөр торгож, 851 хүнийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 66 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Цэцүүх Трейд” ХХК нь Улаанбаатар хот, Налайх дүүргийн 3-р хорооны нутагт дэвсгэрт хэрэгжих “Тэсрэх материалын агуулах” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилсан байдлаар тодорхойлж гаргав.

3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын бохирдол үүсэх үндсэн нөхцөл нь барилгын ажлын явцад ашиглаж буй машин механизм, техник хэрэгслээс гарах химийн хорт бодис бүхий хий, утаа, тортог болно. Агаарын бохирдол нь барилга байгууламжийн ойр орчимд ажиллаж байгаа хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөс гадна ойр орчмын газар нутагт нөлөөлдөг. Бүх төрлийн автомашин, механизм, зөөврийн чанартай бусад хэрэгслүүд агаар орчныг бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэрт хамаарагдана.

Хүснэгт 16. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөх байдлын үнэлгээ

Д/д	Болзошгүй нөлөөлөл	Төслийн аль үйл ажиллагаанаас хамаарах		Нөлөөллийн үнэлгээний хэсэг			
		Тэсрэх материалын агуулахын хадгалалт ашиглалтын явцад	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Бага	Дунд	Их	Маш их
Төслийн талбайн хэмжээнд							
1	Агаарын чанар	Аммиакын шүүг хадгалах явцад тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэл болон химийн бодис хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй, хамт хадгалах хориотой бодисын хамт хадгалсан тохиолдолд химийн бодис асгарах, алдагдах зэргээр агуулахын дотоод орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	Орчны агаар, хөрс, ургамалд нөлөөлнө.		+		
2	Агаарын чанар	Тэсрэх материалыг тээвэрлэх машины тоног төхөөрөмж, ялангуяа дизель түлшээр ажилладаг хүнд даацын машин, техникийн хорт утаа ялгарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө	Ажилчдын болон иргэдийн эрүүл мэнд, орчны агаар, хөрс, ургамалд нөлөөлнө.		+		
3	Агаарын чанар	Тухайн төслийн агуулахын талбайн хэмжээнд газрын гадаргуу хэсгийн хөрсгүйжүүлсэн талбай болон зам зэргээс тоног төхөөрөмжийн хөдөлгөөний эрчим, тээвэрлэлт, байгалийн салхи зэргийн нөлөөллөөс хамааран агаарт тоосжилт үүсэх	Орчны агаар, хөрс, ургамалд нөлөөлнө		+		

Дээрх хүснэгтээс харахад агаар орчинд нөлөөлөх нөлөөлөл зайлшгүй бөгөөд буцалтгүй шинж чанартай байх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө хэрэгжилтээс шалтгаалан бууруулах боломжтой нөлөөллүүд юм.

3.2 ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих бүтээн байгуулалтын үйл ажиллагааны улмаас нийт 10000 м.кв талбайд төсөл хэрэгжинэ.

Хүснэгт 17. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Д/д	Болзошгүй нөлөөлөл	Төслийн аль үйл ажиллагаанаас хамаарах		Нөлөөллийн үнэлгээний хэсэг			
		Тэсрэх материалын агуулахын хадгалалт ашиглалтын явцад	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Бага	Дунд	Их	Маш их
Төслийн талбайн хэмжээнд							
1	Хөрсөн бүрхэвч	Тэсэлгээний материал тээвэрлэх /машины тоног төхөөрөмж, ялангуяа бодисыг ил задгай тээвэрлэх, сав баглаа боодол нь эвдэрч гэмтсэн/ үед цас борооны усаар угаагдан норж машины тэвш, газарт химийн бодис үлдэх зэргээр хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө.	Ажилчдын болон амрагчдын эрүүл мэнд, орчны агаар, хөрс, ургамалд нөлөөлнө.		+		
2	Хөрсөн бүрхэвч	Машин техникийн засварыг зориулалтын бус газар хийснээр тос масло асгарах хөрсөн бүрхэвч бохирдох	Ажилчдын болон иргэдийн эрүүл мэнд, орчны агаар, хөрс, ургамал, гүний усанд нөлөөлнө.		+		
3	Хөрсөн бүрхэвч	Агуулах барих ажилчдын байр, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.	Ажилчдын болон иргэдийн эрүүл мэнд, орчны агаар, хөрс, ургамал, гүний усанд нөлөөлнө		+		
4	Хөрсөн бүрхэвч	Тээвэрлэх ачиж, буулгах үед аюулгүй ажилгааны дүрмийг баримтлаагүйн улмаас хөрсөн дээр асгарах, хөрсөн бүрхэвч бохирдох	Ажилчдын болон иргэдийн эрүүл мэнд, орчны агаар, хөрс, ургамал, гүний усанд нөлөөлнө		+		

3.3 ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Төслийн талбай нь Туул голын усны сав газарт хамаарна.

Хүснэгт 18. Гадаргын болон гүний усанд нөлөөлөх байдлын үнэлгээ

Д/д	Болзошгүй нөлөөлөл	Төслийн аль үйл ажиллагаанаас хамаарах		Нөлөөллийн үнэлгээний хэсэг			
		Тэсрэх материалын агуулахын хадгалалт ашиглалтын явцад	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Бага	Дунд	Их	Маш их
Төслийн талбайн хэмжээнд							
1	Газрын доорх ус	Тээвэрлэх /машины тоног төхөөрөмж, ялангуяа химийн бодис ил задгай сав баглаа боодол эвдэрч гэмтсэн/ үед цас борооны усаар угаагдан норж машины тэвш, газарт химийн бодис үлдэх зэргээр хөрс, гадаргын болон гүний усны чанарт сөргөөр нөлөөлнө	Орчны агаар, хөрс, ургамал, гүний усанд нөлөөлнө.	+			
2	Газрын доорх ус	Шингэн хаягдал болон ахуйн бохир усыг цуглуулан хураах бохир усны савыг “Ахуйн бохир ус хадгалах цооногийг доторлож	Орчны агаар, хөрс, ургамал, гүний усанд нөлөөлнө		+		



		ашиглах журам”-ын дагуу байгуулах шаардлагатай					
3	Газрын доорх ус	Ахуйн бохир ус дамжуулах шугам хоолойн битүүмжлэлийг сайжруулах			+		

3.4 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн талбайд: Хялгана-хиагт бүлгэмд хамаарна.

Хүснэгт 19. Ургамлан нөмрөгт үзүүлэх болзошгүй нөлөөлөл

Д/д	Болзошгүй нөлөөлөл	Төслийн аль үйл ажиллагаанаас хамаарах		Нөлөөллийн үнэлгээний хэсэг			
		Тэсрэх материалын агуулахын хадгалалт ашиглалтын явцад	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Бага	Дунд	Их	Маш их
Төслийн талбайн хэмжээнд							
1	Ургамлан нөмрөг	Агуулах руу аммиакийн шүү тээвэрлэж буй автомашинууд олон салаа зам гаргаж ойр орчмын ургамлан бүрхэвчийг гэмтээхгүй байх	Орчны агаар, хөрс, ургамалд нөлөөлнө.			+	
2	Ургамлан нөмрөг	Төслийн талбайгаас гарах хатуу, шингэн хог хаягдал	Ажилчдын болон иргэдийн эрүүл мэнд, орчны агаар, хөрс, ургамалд нөлөөлнө.		+		
3	Ургамлан нөмрөг	Замын тэмдэг байршуулаагүй улмаас олон салаа зам үүсч ургамлан нөмрөгт нөлөөлөх	Хөрс, ургамалд нөлөөлнө.		+		



БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдөр дугаар А/618 тоот байгаль хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болдог. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээг, хугацаа, хөрөнгө зардал, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тооцож төлөвлөгөөнд тусгалаа.

Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн

№	Зардлын ангилал	2025 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	250,000
2	Орчны тохижилт, Нөхөн сэргээлт	1,140,000
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,900,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,475,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	850,000
6	Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	100,000
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Түүх, соёлын дурсгал байхгүй.
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Газрын маргаан болон давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй.
9	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ байхгүй.
	Нийт дүн	7,715,000



БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 21. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө						
Төсөлд ашиглагдах машин механизм, дизель машины яндангаас ялгарах утаан дахь агаар бохирдуулагч хорт хийнүүд	Машин механизмуудад засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж техникийн хяналтыг тогтмол хугацаанд хийлгэн чанартай түлш шатахуун хэрэглэж байх зэрэг нь ялгарах хорт утааны хэмжээг стандартад заасан зохих зөвшөөрөгдөх хэмжээнд нь барихад тус болно.	Тээвэрт хэрэглэгдэх бүх автомашин, механизмуудад Жилд 1 удаа		Дотоод төлөвлөлтөөр	2025 он	“Агаарын тухай” хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. Монгол улсын стандарт MNS 5013:2003 MNS 5014:2003
Агааржуулалтын системд гэмтэл, доголдол гарч, хадгалалтын горим алдагдах	Агааржуулалтын ажиллагаа хэвийн байгаа эсэхэд урьдчилсан шалгалт үзлэг тогтмол хийх	Тэсрэх материалын агуулахын агааржуулах системд Сард 1 жилд 12 удаа		Дотоод төлөвлөлтөөр	2025 он	MNS 5013:2003 MNS 5014:2003
Ууршилттай болох хуурай химийн бодисын битүүмжлэл алдагдан хугацаа алдсанаар гадаад орчинд тархах	Химийн бодисыг хадгалах явцад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх, савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах, Орчны агаарын чанарын хяналт шинжилгээг хэрэгжүүлэх,	Агуулахын гадаад орчин		Дотоод төлөвлөлтөөр	2025 он	MNS5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө						
Тэсрэх материалын агуулах ажлын улмаас хөрсөн бүрхэвч бохирдож нягтарснаар хөрсний үржил шим	Нягтаршиж бохирдсон талбайг тэгшлэн сийрэгжүүлж ургамалжуулах,	Тэсрэх материалын агуулах нийт талбайн орчим		Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан	2025 он	Газрын тухай хууль 56-р зүйл-56.2 Хөрс хамгаалах, цөлжилтөөс



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ийн “ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ”- ний ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

буурах	Орчны тохижилтын ажлыг зураг төсөлд заагдсаны дагуу гүйцэтгэх		болно.		сэргийлэх тухай хууль 6, 7-р зүйл
Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс байгууламжуудын дор дарагдаж, зам тээвэр, бүтээн байгуулалт болон бусад үйл ажиллагаатай холбогдож элэгдэл, эвдрэлд өртөнө.	Тэсрэх материалын агуулах үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах	Тэсрэх материалын агуулах нийт талбайн орчим	250,000	2025 он	MNS 3307:1991, MNS 3308:1991Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,
	Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих (өнгөт хавтан, чулуу, хөндий банзан г.м), сэргээн засварлаж байх	Тэсрэх материалын агуулах нийт талбайн орчим	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2025 он	-MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө					
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Төслийн талбайд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2025 он	Газрын тухай хуулийн /58.5/
Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101 болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ,стандартын хэрэгжилт		Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2 жилд 1 удаа	Байгаль орчныг Хамгаалах тухай хууль /3.2.14/
Сумын санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		2025 он	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Үйл ажиллагааны туршид	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		2025 он	Байгаль орчныг Хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн биелэлтийн тайланг жил бүр НБОГ хүлээлгэн өгөх	Жил бүрийн 12 сард	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		2025 он	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Нийт 150,000					


БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Салхины хаалт хамгаалалтанд хашаалж ургадаг мод тарих боломж, туршилтыг судалж нэвтрүүлэх хэрэгтэй. Оффис, ажлын байрны орчимд цэцгийн мандал байгуулах, үйлдвэрээс хязгаарлагдсан талбайд мод тариалах ажлыг нөхөн сэргээлт, тохижилтын төлөвлөгөөнд тусгасан байх хэрэгтэй. Ер нь газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Нөхөн сэргээлт, орчны тохижилтыг ерөнхий төлөвлөгөө болон байгаль хамгаалах төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлтөд заасан хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

Ингэхдээ дараах арга технологийг баримтална.

1. Төслийн хэрэгжилтийн явцад эвдэгдэх бүх талбайн шимт хөрсийг 0.3м-ийн зузаантай хуулан нөхөн сэргээлтэд бэлтгэж Монгол Улсын (MNS 5917:2008) стандартын дагуу хадгалах
2. Нөхөн сэргээлтэд хэрэглэх шимт хөрс нь аль болох байгалийн унаган төрхтэй хөрсний шинж чанартай ойролцоо байвал зохимжтой учир хадгалах, ашиглахдаа анхаарч байх шаардлагатай. Үржил шимт хөрсийг хэт гүн хуулах зэрэг нь үржил шим багатай, хайрга, чулууны агууламжийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй байх бөгөөд органик бодисын агууламжийг нэмэгдүүлэх, чулуулгийг багасгах шаардлага үүсдэг.
3. БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний ургамал, нөхөн сэргээлт, орчны тохижилтын ажлыг гүйцэтгэхдээ агуулах болон ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зохих стандартын дагуу биологийн нөхөн сэргээлт явуулах арга технологийг баримтлан ажиллана.

1. Суулгацын нүх ухах. Мод, сөөгийг ургуулахад анхаарах нэг гол зүйл бол суулгах нүхийг зөв ухаж бэлтгэх байдаг. Мод сөөгний төрөл зүйлийн онцлогоос хамааран суулгах нүхний голч, гүн зэрэг нь янз бүр байдаг. Гүн 30-50см Диаметр 40-60см



2. Хөрс бэлтгэх. Сөөг бутны нүхийг 0.6м голтой 0.5м гүн ухаж бэлтгэнэ. Үүний дараа тус орчинд ус чийгийг тогтоон барих зорилгоор нүхний ёроол болон ханыг услаж чийглэх, элсэрхэг хайрган бүтэцтэй нүхний ёроолыг шар шавраар доторлоно.




3. Суулгацыг тарих. Мод сөөгийг суулгахын өмнө бэлтгэсэн нүхийг ханатал усалж чийгшүүлэн холимог шороог нүхний 2/3 хүртэл ялимгүй хонхойлгоод дээр нь суулгацыг нэг хүн барьж нөгөө нь үндсийг нугалахгүйгээр тал бүр салбарлуулан нямбай тараан дээрээс нь шороо бага багаар хийж гараар дарж нягтруулна.

Суулгацын ишийг дээш нь зөөлөн татаж хөдөлгөхөд үндэсний завсраар шороо сайтар орж чигжигдэнэ. Ингэж суулгах явцдаа нүхний ханан талыг сайн чигчиж өгөх нь усыг үр ашиггүй алдахаас сэргийлэх сайн талтай байдаг.

Суулгацны үндэсний хүзүү газрын гадаргаас 7-8м доор байхаар суулгаж хүзүүг 4-5см зузаан шороогоор дарж өгөөд шороог гишгэж сайтар нягтруулна. Ингэхдээ суулгацны үндэс орчмыг өлмийгөөрөө зөөлөн гишгэнэ. Хүчтэй гишгэвэл үндэс гэмтэж тасарна.

Үүний дараагаар нөөцөлсөн шороогоор 10-15см өндөртэй тогоо хийж хүрээр давтах, өлмийгөөрөө гишгэх зэргээр нягтална.

Суулгацыг тарихдаа нүхний голд үндсийг нугалахгүйгээр жигдтарааж суулгана.50% хар шороо, 30% элс, 20% хөх бууц бусад бордоог хийнэ.




5. Тарилтын дараах арчилгаа

Өглөө оройн цагаар 7-10 хоногт 40-50 л усаар 1 модыг 1-2 удаа услана. Усалгаа хийх явцад хөрсний сийрүүлэлт хийнэ.



4. Услах арга.Мод сөөгийг суулган шороог гишгэж сайтар нягтруулсны дараа нэг модонд 70-80л, нэг сөөгөнд 20-30л ноогдохоор бодож тарьсан өдөрт нь багтаан усална. Усалгааны үед ил гарсан үндсийг булах, хазайсан суулгац, модны нүхний тогоон дотор үүссэн хонхорыг тэшглэх ажлыг цаг алдалгүй хийх суулгацыг орчинд дасгаж ургуулахад зайлшгүй чухал байдаг. Үүнээс 2-3 хоногийн дараа 2 дахь усалгааг нэг модонд 30-40л, сөөгөнд 20-25л ус ноогдохоор бодож услана. Усалгааны хэмжээг дээрх байдлаар, хоорондын хугацааг 8-р сарын 15-ныг хүртэл баримтлах бөгөөд энэ үеэс эхлэн 10-14 хоногт 1 удаа услах нь зүйтэй. Намар 9-р сарын хоёр дахь 10 хоногоос усалгааг зогсооно. Мод бутыг өглөө, оройн сэрүүнд уславал шингэц сайн, ууршилт алдагдал бага байдаг.



6.Байгальд дасанзохицож ургах

3 жилийн дараагаас арчилгаа усалгааг хийх шаардлагагүй болно.





“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ийн “ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ”- НИЙ ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 22.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн талбайн хашаалалтын дагуу мод, бут тарих	Шилмүүс, хайлаас тарьж ургуулах	Хашааны дагуу -хуайс	ш	30	10000	300,000	2025 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж
“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайд тарималжуулах	Монгол гацуур	Төслийн талбай дотор гацуур	ш	8	105000	840,000	2025 он	МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Нийт дүн: 1,140,000								

БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 23.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж өртөг	Нийт зардал	Хариуцах эзэн	Баримтлах хууль, журам, стандарт
Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл						
Болзошгүй осол аваар гарах, ажиллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөнөөс аюул	Ажлын идэвхтэй талбайг тойруулан хангалттай/зохистой гэрэлтүүлж, гэрэл цацруулагч саад (боломжтой бол, түр хашаа барих) тавих,	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны хүрээнд	Ерөнхий инженер	MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS ISO13688:2000, “ХААЭА.
	Явган хүмүүс, оршин суугчид осолгүй орж гарах боломж олгох	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр			



осолд өртөх	Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж),	Үйл ажиллагааны хүрээнд	500,000	Ерөнхий инженер, ХАБЭА инженер	Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS5010:2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNSILOOSH1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж” MNSILOOSH 0:2003, “ХААЭА. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS5390:2004,“ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
	Төслийн тухай мэдээллийн самбар, ажил эхлэх, дуусах хугацаа, Гүйцэтгэгчийн нэр, холбоо барих хаяг, талбайн удирдах ажилтан, ачааны машинуудын явах зам, дэд төслийн зохион байгуулалт зэргийг мэдээлнэ.	Үйл ажиллагааны хүрээнд	1,500,000		
	Ойр орчмын албан байгууллага, орон сууцны аюулгүй байдлын талаар удирдах байгууллагатай зөвшилцөх.	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр		
Ажилчдын эрүүл мэнд					
ХАБЭА-г хангаагүйгээс бэртэж гэмтэх, амь насаа алдах Мэргэжлийн өвчин тусах	Ажилчид, тоног төхөөрөмжийг авчрахаас өмнө ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, аюулгүй байдлын дүрмийг хатуу мөрдөх талаар танилцуулна	Үйл ажиллагааны хүрээнд		Ерөнхий инженер, ХАБЭА инженер	
Тоос, дуу чимээ, газны ялгарал, үнэр, чичиргээ	Хамгаалах хэрэгсэл, нүдний маск, хамрын маск, чихний бөглөө, хатуу малгай, бээлий, тохиромжтой гутал зэрэг ХАБЭА-н хэрэгслээр бүрэн хангах, байнга өмсгүүлж, хэрэглүүлэх	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	Ерөнхий инженер, ХАБЭА инженер	
	Ажлын талбай руу аюулгүй орох, гарахыг тэмдэгжүүлэх,	Үйл ажиллагааны хүрээнд	100.000	Ерөнхий инженер, ХАБЭА инженер	
	Найдвартай ундны ус хангамжтай, ариун цэврийн хангалттай тоног хэрэгслүүдтэй, аюулгүй сууцаар хангах	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр	Ерөнхий инженер, ХАБЭА инженер	
	Үйлдвэрийн ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагаа, осолтой төхөөрөмж хэрэгслийг ажиллуулах	Үйл ажиллагааны хүрээнд			



Хаягдал, бохир усны менежмент хангалтгүй байх	талаар сургалт хийх					
	Ажил эрхлэх эрүүл мэндийн сертификатыг ажилчдаас авах, ажилчдын эрүүл мэндийн суурь мэдээлэл бий болгох	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр			
	Ажилчдын эрүүл мэнд, онцгой нөхцөлд холбоотойгоор хамгийн ойрын анхдагч болон гуравдагч шатны эрүүл мэндийн байгууллагатай гэрээ хийх	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр		Ерөнхий инженер, ХАБЭА инженер	
	Хамгаалах арга хэмжээ аваагүй, эсвэл хангалтгүй байснаас гэмтэл үүсгэвэл хохирлыг (бодит үнэ цэнээр) Гүйцэтгэгч төлнө.	Үйл ажиллагааны хүрээнд				
Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр						
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс барилгын үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Үйл ажиллагааны хүрээнд	Нийслэлийн Цаг уур орчны шинжилгээний газартай тохиролцох		2025 он	Ус цаг уур, орчны хяналт Шинжилгээний тухай хууль, 15-р зүйл MNS 4585:2007
Гал түмрийн улмаас барилгын үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчидад тогтмол хугацаанд танилцуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр		2025 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны хүрээнд			2025 он	
Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас барилгын үйл ажиллагаа доголдох, зогсох	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчидад тогтмол хугацаанд танилцуулах	Үйл ажиллагааны хүрээнд	200.0*4=800.0	800,000	2025 он	Гамшгаас хамгаалах тухай, 27-р зүйл
Ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр						
Болзошгүй осол аваар гарах, ажиллагсад	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг	Үйл ажиллагааны	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		2025 он	MNS 4990:2000 MNS 4969:2000



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ийн “ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ”- ний ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөнөөс аюул осолд өртөх	сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	хүрээнд Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 15-р зүйл
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх				
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах				
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих				
Төслийн болзошгүй эрсдлийг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын таван жилийн зардал: 2,900,000					

БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 24. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хууль	2025 он	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад			Тухайн үед нь шийдвэрлэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглээний норм, гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 25. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, төг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
--	--	-----------------	----------------	------------	---------------------	---------------------------	--------------------------------------	-------------------------------------



Хог хаягдлыг ил задгай хаяснаар орчны бохирдол үүсгэх	Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу кодлон ангилж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Тэсрэх бодисын агуулахын талбай	хүн/өдөр	55 удаа /7 хоногт 1 удаа, шаардлагатай үед 2 удаа /	45.0*55=2,475,000	2,475,000	2025 он	Хог хаягдлын тухай хууль, 9-р зүйл Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн А-116 дугаар тушаалын хавсралт
Хог хаягдлыг ил задгай хаяснаас хөрс доройтох	Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, битүү саванд хадгалан тогтмол хугацаанд тээвэрлүүлж байх	Тэсрэх бодисын агуулахын талбай	т	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах			2025 он	MNS: 5850:2008 MNS: ISO 11074-1:2001

Тухайн жилийн зардал 2,475,000

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Бид 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон давтамжийг тусгалаа.

Хүснэгт 26. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө

Бүрэлдэхүүн	Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төгрөг	Баримтлах стандарт ба арга аргачлал
Усан орчин	pH Химийн хэрэгцээт хүчилтөрөгч Умбуур бодис Аммиак Био химийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ5)	Төслийн талбай	Жилд 1 удаа буюу 10 сард уснаас дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	150.0 (Химийн бүрэлдэхүүн ба Хүнд металлын шинжилгээ)	150,000	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг, кадми Cd, кальци Ca, зэс Cu, хүнцэл As, мөнгөн ус Hg, кобальт Co, никель Ni, хар тугалга Pb, сод Na, магни Mg, төмөр Fe, цинк Zn, сульфат SO ₄ , хүчил саармагжуулах чадвар, хүчил үүсгэх чадвар ANP/AGP, чулуулгийн найрлага	Төслийн талбайг бүрэн хамруулан үйлдвэрийн ажил явагдаагүй 5 цэгт. Мөн төслийн талбайн гадна салхины доод талд орших 3 цэгт.	Жилд 1 удаа буюу 10 сард хөрсний дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	50.0 (Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмагийн шинжилгээ) 50.0	400,000	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ийн “ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ”- НИЙ ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	АВА, нийт сульфит Total Sulfur, ялгардаггүй сульфат S N-Ex, пиритийн сульфит P-Sulfur, pH	Нийт 8 цэгт.		(Хөрсний хүнд металлын шинжилгээ)		үзүүлэлтийг тодорхойлох
Агаарын чанар	-Тоосжилт (PM10,PM25) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ Ажлын байрны эрүүл ахуйн Үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) Бохирдлын цэгэн эх үүсвэр (SO2, NO2, CO2)	Төслийн талбайг бүрэн хамруулан 5 цэгт (тоосжилт үүсэж буй болон тоосжилтгүй). Мөн төслийн талбайн гадна салхины доод талд орших 3 цэгт. Нийт 3 цэгт.	Жилд 2 удаа буюу 4 болон 10 саруудад мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө. (3 цэг*2 удаа)	50.0	300,000	MNS4990:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй.
Нийт:850,000						

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 27. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Ерөнхий үнэлгээ хийсэн төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-г боловсруулан хүргүүлж, батлуулна.	– Төслийн товч танилцуулга – Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	Жил бүрийн 12-р сард багтаана	БОМТ-ний хэрэгжилтийг хүлээн авч дүгнэх, дараа жилийн төлөвлөгөөг хянан батлах ажлыг ажлын 21 хоногт багтааж, шийдвэрлэнэ.	БОУАӨЯ-ны Хүрээлэн буй Орчин, Байгалийн Нөөцийн Удирдлагын газар
/БОУАӨЯ/-ны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим системээр илгээх eic.mn	БОМТ-ний биелэлтийн тайланг хүргүүлнэ.	– Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт – Өмнөх жилийн БОМТ-ний биелэлт	Жил бүрийн 11-р сарын 1-ны дотор	Биелэлтийг дүгнүүлэх	/БОУАӨЯ/
Зардал, төг: 100,000					